

АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Монгол улсын бүх нийтийн бэлэн байдлын зэргийг Монгол Улсын Засгийн газраас сугасантай холбоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар зохион байгуулахаар шийдвэрлэж, хурлыг цахимаар бэлтгэх зохион байгуулах ажлыг төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга И.Артём гүйцэтгэв.

Хурал зохион байгуулах комиссын гишүүд, Тооллогын комиссын гишүүд, хуралд оролцохдоо яриагүй үедээ микрофоноо хаах, зөвхөн ярих үедээ нээх зөвлөгөө өгөв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 27-ний 10:00 цагт “Zoom Meeting” программ ашиглаж Meeting ID: 3531383808 гэх хаягаар эхлэв.

Хурлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Мөнхдалай даргалж, хурлын нарийн бичгийн даргын үүргийг И.Артём, Тооллогын комисст Ч.Жадамба, Э.Түвшинбаяр, Ц.Энхтүвшин нар тус тус ажиллав.

Тус хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн С.Бямбахорлоо, Атар-Өргөө ХК-ийн Санхүү эдийн засгийн албаны дарга Ц.Отгондулам, Эдийн засагч С.Гантуул нар оролцов.

Хурлын дарга **Б.Мөнхдалай**: Хуралд оролцохоор онлайн хуралд орсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн бүртгэл, хурлын ирцийн талаар Тооллогын комиссыг мэдээлэл өгөхийг хүсэв.

Тооллогын комиссын дарга **Ч.Жадамба**: Сайн байцгаана уу, та бүхэнд өглөөний мэнд хүргэе хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцтэй холбоотой тооллогын комиссын тогтоолыг та бүхэнд уншиж танилцуулъя. Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол 2021 оны 04 сарын 27-ны өдрийн дугаар 01 Улаанбаатар хот. Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 сарын 27-ны өдрийн ээлжит хуралд оролцохоор ирсэн саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн ирцийг тоолсон Тооллогын комиссын дүнг үндэслэн тогтоох нь. Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 174,136 ширхэг буюу 1,567,224 саналын эрх бүхий энгийн хувьцаа эзэмшдэг 347 хувьцаа эзэмшигчид оролцохоос 88,044

ширхэг буюу 792,396 саналын эрхтэй 6 хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр болон итгэмжлэлээр оролцохоор хүрэлцэн ирсэн нь нийт саналын эрхийн 50,56 хувь болж байгааг мэдэгдэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын 2021 оны 04 дүгээр сарын 27-ний 01 дүгээр тогтоолыг уншиж танилцуулав. (Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав)

Б.Мөнхдалай: Тооллогын комиссын дарга Ч.Жадамбад мэдээлэл өгсөнд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Дээрх мэдээллийг үндэслэн өнөөдрийн Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эхэлснийг мэдэгдэж байна. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх гол асуудлуудын жагсаалтыг би та бүхэнд танилцуулъя. Нэг дүгээрт Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт хэлэлцэж батлах мөн компанийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийсэн тухай мэдээлэл өгөх, ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дотоод ажлын зардлын төсвийг батлах гэсэн дараалалтай явагдана. Хурлын дэгийн дагуу Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт: Төлөөлөн удирдах зөвлөл Атар-Өргөө ХК-ийн 2020 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, Санхүүгийн 2020 оны тайлан, Атар-Өргөө ХК, түүний алба, нэгж, Гүйцэтгэх удирдлага ийм зүйлүүдийг багтаасан тайланг үндэслээд өнгөрсөн 2020 онд 9,4 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 193,8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Энэ хоёр тоо манай компанийн талаар өнгөрсөн 2020 оны талаар олон зүйлийг өгүүлж байгаа. 2020 онийг ерөнхийлөн дүгнэх юм бол компани өөрийн дотоод нөөц бололцоон дээр тулгуурлаж компанийн тулгамдаад байгаа гол асуудлуудыг шийдэхэд анхаарч ажилласан дүр төрх ажиглагдаж байна. Гол онцлох зүйл гэвэл 2016 оноос ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, ач холбогдол өгч ажилласан, энэхүү тогтолцоог улам сайжруулах чиглэлд ажилласан байна. Компанийн орлогийн дүн өнгөрсөн жилээс буурсан 9.4 тэрбум төгрөг гэдэг тоо тийм юм илэрхийлж байгаа гэж ойлгож байна. 2020 оны нөхцөл байдлын талаар дүгнэж Төлөөлөн удирдах зөвлөл дээр ярилцсан. 2020 он гарснаар давагдашгүй хүчин зүйлүүд гарч эхэлсэн, үүнтэй холбоотойгоор хүмүүсийн худалдан авах чадвар оны туршид буурсан үүнээс үүдэн компанийн борлуулалтын хувь тодорхой хэмжээгээр буурсан гэж ажиглагдаж байгаа. Дотоод хяналтыг сайжруулах замаар үйлдвэрлэлийн өгөөж ажил үүргийн хуваарийг нэмэгдүүлсэн гэж байгаа. Нөхцөл байдал хэцүү үед бидний хамгийн чухал асуудал дотоод нөөц бололцоогоор хөрөнгө мөнгийг бүтээх тал

дээр анхаарч ажилласан. Жишээлбэл өмч, хөрөнгийн, бэлэн болон бэлэн бус мөнгөн хөрөнгийн зарцуулалтын дагуу үр ашигтайгаар үйлдвэрлэлд ашиглахад анхаарч ажилласан. Санхүүгийн хяналтыг улам сайжруулсан. Олон жил дамжиж ирсэн дутагдалтай зүйл бол үйлдвэрийн дотоод санхүүгийн анхан шатны бүртгэлүүд юм. Энэ талаар ярилцаж нэмэлт анхан шатны бичиг баримтуудыг бүрдүүлж цаг үеийн хяналтыг үйлдвэрийн дотоод ажилд оруулж дотооддоо тодорхой хэмжээний хөрөнгө, нөөц байгааг олж харсан юм. 2020 оны нэг том ажил бол эрсдэлд суурилсан бодлогын бичиг баримтыг шинэчлэн баталсан. Жилийн жилд хэвийн явагдаж байдаг эдийн засгийн орчин гэдэг дээр бид нар тулгуурлаж бизнес төлөвлөгөөгөө хийж ирсэн байгаа. Ингээд тайлант он дуусахад бизнес төлөвлөгөөний биелэлт бол хангалтгүй гараад байгаа. Энэ асуудлын шалтгаан нь эрсдэл тооцохгүйгээр бизнес төлөвлөгөө баталсанд оршиж байгаа. Ийм учраас бид энэхүү бичиг баримтыг баталж гаргасан байгаа. Эрсдэл тооцохыг чухал гэдгийг бид нарт энэхүү шинэ цар тахалтай орчин нөхцөлүүд ойлгуулаад байгаа. 2020 онд өөрийн хөрөнгөөр шинэ тоног төхөөрөмжүүдээр үйл ажиллагаагаа сайжруулсан. 1941 оноос хойш үндсэндээ 1-р үйлдвэр засвар явагдаагүй байсан. 2018, 2019 онд мэргэжлийн хяналтын байгууллагаас удаа дараа энэ тал дээр анхааруулга өгдөг байсан. Засварын ажил өндөр зардалтай байсан тул их төлөвлөж 2020 онд зоригтойгоор шийдвэрлээд, Төлөөлөн удирдах зөвлөлөөс энэхүү хөрөнгийг гаргах зөвшөөрлийг удирдлагуудад өгч үйлдвэрийн стандартын дагуу засвар хийсэн байгаа. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж ажилласан байна мөн үйлдвэрийн үйл ажиллагааг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн, үйлдвэрлэлийн өгөөжийг нэмэгдүүлж ажилласан байна. Энэ талаар гүйцэтгэх захирлаас Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж байгаа үйл ажиллагааны тайланд тусгагдсан бөгөөд үйл ажиллагааны үр дүнг тайландаа бүрэн зөв тусгасан байна гэж үзэж, гүйцэтгэх захирал чиг үүргээ хангалттай сайн биелүүлсэн гэж үзэж дүгнэлт гаргаж байна. Атар-Өргөө ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа, борлуулалтын орлого, үйлдвэрлэлийн зардлын харьцааг харгалзан үзэж компанийн цэвэр ашгийн тоон үзүүлэлтийг харгалзан компанийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрийг бид гаргасан. Энийг яах аргагүй нарийн тайлбарлаж өгөх зүйл гэж бодож байна. Хувьцаа эзэмшигчид ногдол ашиг авахыг хүсэх нь зүй ёсны хэрэг. Гэвч энэ дээр тодорхой хэмжээний тайлбар тавьж та бүхнийг дэмжинэ гэдэгт найдаж байна. Ногдол ашиг тараахгүй байх гол үндсэн зүйл бол 2020 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явцад хэрэглэгчдийн худалдан авах чадвар Дэлхий нийтийг хамарсан цар тахлаас болж буурсан. Мөн үйлдвэрийн стандартыг урагшлуулхийн тулд зайлшгүй шаардлагаар 1-р үйлдвэрт стандартын дагуу, дотоодоос зардал гаргаж засвар хийсэн юм. Үүний зэрэгцээгээр бид 2020 оноос эхлээд Засгийн

газрын өргөн хэрэглээний барааны үнийг нэмэхгүй байх уриалгыг дэмжиж энэхүү хүнд үед ашиг орлогоо хөөх ёс зүйн хувьд зохимжгүй гэж үзэж бүтээгдэхүүний үнийг нэг төгрөгөөр ч нэмэгдүүлээгүй. Гэтэл үндсэн импортын түүхий эд болох элсэн чихэр ургамлын тос тэр ч бүү хэл дотооддоо үйлдвэрлэдэг гурлын үнэ хүртэл өссөн. Энэ нь компанийн ашигт муу нөлөөлсөн нь ойлгомжтой байх. Ийм зүйлүүд тохиолдсон учир бид компанийн тогтвортой ажилахыг илүүд үзэж хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг тараахгүй байхыг оновчтой гэж үзэж энэхүү шийдвэрийг гаргасан. Одоо надаас лавлах зүйл эсвэл санаа оноо байвал хэлээрэй. (Хурлаар хэлэлцсэн асуудлын танилцуулга, мэдээллийг хавсаргав)

Б.Мөнхдалай: Энэ тал дээр ямар нэгэн санал өгөх хүн байхгүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох ажилдаа орий. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшигч нарын товч танилцуулгууд материалаараа тараагдсан байгаа. Нэмж танилцах хүн байвал дэлгэцэн дээр ай ти инженер харуулж болно. Энэ талаар асуух шаардлаггүй бол бүгд мэдэж байгаа гэж ойлгож үзлээ.

Б.Мөнхдалай: Дараачийн бидний асуудал бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоож зардлыг батлах тухай гэсэн байна. Үүнийг нэг бүрчлэн уншиж цаг барснаас дэлгэцэн дээр харуулах уу, хэрвээ шаардлагатай бол би уншиж танилцуулъя. Төлөөлөн удирдах зөвлөл нийт 9 гишүүнтэй байна нэгж цалин 420 мянган төгрөг нийт 45.360.000 төгрөг, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хурлын ирцийн урамшуулал хүн болгоны 100.000 төгрөг жилийн хэмжээнд 3.600.000 төгрөг төлөвлөгдсөн, Нарийн бичгийн даргын цалин 1.500.000 төгрөг жилийн хэмжээгээр бол 18.000.000 төгрөг, нийтдээ цалин урамшуулалд 66.960.000 төгрөг батлуулахаар оруулсан байна. Дараагийн асуудал Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын зардал гэж байна. Энд бүртгэл судалгаа, зуучлалын гэрээний хөлс, өдрийн сонин, телевиз, зар мэдээнүүд, ТУЗ-ийн гишүүдийн сургалт, ажил төрлийн уулзалт, семинар, үнэт цаасны бүртгэлийн хураамж, хадгаламжийн хураамж гэх зүйлүүдийг нэгтгээд нийтдээ 6.630.000 төгрөг батлахаар төлөвлөсөн байна. Энэ талаар санал шүүмжлэл байвал хүн тус бүр дээр 5-7 минут гэсэн байгаа, санал бодлоо илэрхийлээрэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн С.Бямбахорлоо: Аудитын хорооны дүгнэлтийг танилцуулах шаардлага байгаа болов уу?

Б.Мөнхдалай: Манайх Мүүрь аудит гэх нэлээн нэр хүндтэй компаниар аудитын дүгнэлт хийлгэж байгаа, гол нь аудитын компануудийн ерөнхий чигийг хараад байхад

цар тахлын асуудалтай холбоотой тэдний ажил бага зэрэг саатаж байгаа гэж үзэж байна. Удахгүй аудитын дүгнэлт бэлэн болох байх. Өөр тодруулж лавлах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигч Б.Анхбаяр: 9.4 тэрбум төгрөгний борлуулалт хийчихээд зуун хэдэн сая төгрөгний ашигтай ажиллаж байгаа юм уу? Өмнө хэзээ ногдол ашиг хуваарилаж байсан бэ? Ирэх жил хуваарилах болов уу?

Б.Мөнхдалай: Өмнө нь бид нар 10 гаран тэрбум төгрөгний борлуулалт хийгээд 200-300 сая төгрөгний ашиг олдог байсан. Тэр үед бид орлогоосоо хамаарч тодорхой хэмжээгээр ногдол ашиг тарааж байсан. 2021 оны эхний улирал одоогоор дуусаж байна гэтэл өнөөдрийн байдлаар энэ жил нэлээн төвөгтэй байх нь харагдаж байна, тайлант оны эцэст байдал өөрчлөгдөхгүй байх, мэдээж байдал сайжирвал ногдол ашиг тарааж таарна. 2022 онд ногдол ашиг тараах үгүй нь бидний гаргасан амжилтаас хамаарна. Надад бол 2021 он 2020 оноос илүү гарахгүй гэх таамаг байна гэвч бид нар үүнийг урьдчилж яриад яахав. Компанийн бодлого бол аль болох хувьцаа эзэмшигчдийн орлогыг нэмэгдүүлэхийн төлөө ажиллах, үүнд анхаарч ажиллаад Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэх болно.

Б.Мөнхдалай: Асуулт асуух, санал гаргах өөр хувьцаа эзэмшигч байна уу. Асуулт асуух, санал гаргах өөр хувьцаа эзэмшигч байхгүй бол асуулт, санал гаргах асуудлыг дуусгах уу. Тооллогын комисс саналын тооллогодоо орох уу.

Тооллогын комиссын дарга Ч.Жадамба: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хүралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид бол саналуудаа өгсөн байгаа, Б.Анхбаярын саналыг саналын хуудсыг нарийн бичгийн дарга И.Артём саналын хуудсаар нь аваад саналаа ирүүлбэл нэгтгээд дүнгээ гаргах боломжтой байна.

Б.Мөнхдалай: Анхбаярт саналын хуудсын маягтын өгсөн байгаа юу?

Нарийн бичгийн дарга И.Артём: Саналын хуудас брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд тараагдсан байгаа, шаардлагатай бол би одоо Б.Анхбаярт дахин явуулъя.

Б.Мөнхдалай: Тооллогын комисс ямар хугацаанд саналыг нэгтгэж бидэнд танилцуулах боломжтой вэ?

Тооллогын комиссын дарга Ч.Жадамба: Анхбаярын саналын хуудас ирснээс хойш 15 минутын дараа танилцуулах боломжтой.

Б.Мөнхдалай: Тэгвэл түр завсарлаж тооллогын комиссын хариу гарахаар нь хуралаа үргэлжлүүлэх саналтай байнаа гэснээр хурал завсарлав.

Б.Мөнхдалай: Тооллогын комиссын ажил дуусч тооллогын дүн гарсан байна. Тоологын комиссын дарга Ч.Жадамба та дүнгээ танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Ч.Жадамба: Тооллогын комиссын дүн нэгтгэгдэж гарлаа, та бүхэнд танилцуулъя. Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол 2021 оны 04 сарын 27-ны өдрийн дугаар 02 Улаанбаатар хот. Саналын хуудсаар санал өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын дүнгийн тухай. Атар-Өргөө ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биеэр болон итгэмжлэлээр оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын дүнг үндэслэн тогтох нь: Нэгд хэлэлцсэн асуудлаар ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл нэг бүрд хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын дүнг дор дурдсанаар баталсугай. Үүнд: Ердийн аргаар өгсөн санал. Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах нийт зөвшөөрсөн 88.044 хувьцаа буюу 100 хувийн саналаар дэмжигдсэн байна. Хоёр дахь асуудал Компанийн 2020 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг зөвшөөрөх нийт 88.044 хувьцаа санал өгөхөөс 99.98 хувь дэмжсэн 0.02 хувь татгалзсан. Гуравт ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрөх тухай 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03 шийдвэрийг зөвшөөрөх тухай Нийт 99.98 хувь дэмжсэн татгалзсан 0.02 хувь. Дөрөвдөх асуудал Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалингийн хэмжээ болон дотоод ажлын зардлын төсвийг төлөвлөсөн төслөөр батлах тухай нийт хувьцаа эзэмшигчид 100 хувийн саналаар дэмжсэн байна. Кумулатив аргаар өгсөн санал. Нэгд Бэрэнбаралын Мөнхдалай 100 хувийн саналаар сонгогдсон байна, Б.Ганбат гишүүн 99.98 хувийн саналаар, Ж.Сайнбилэг гишүүн 99.98 хувийн саналаар, Г.Баттулга гишүүн 99.98 хувийн саналаар, М.Мөнхтэнгис гишүүн 99.98 хувийн саналаар, Г.Энхболд гишүүн 99.98 хувийн саналаар, ердийн гишүүд сонгогдсон байна. Хараат бус гишүүнээр Т.Жигмэддагва гишүүн 99.98 хувийн саналаар, С.Бямбахорлоо гишүүн 99.98 хувийн саналаар, П.Болормаа гишүүн 99.98 хувийн саналаар, Ц.Галтаа 0.02 хувийн саналыг авсан байна. Тооллогын комиссын дарга Ч.Жадамба гишүүд Э.Түвшинбаяр, Ц.Энхтүвшин гэсэн бүрэлдэхүүнээр хувьцаа эзэмшигчдийн саналыг нэгтгэж дууслаа. Саналын хучингүй хуудас байхгүй.

Б.Мөнхдалай: Баярлалаа, өнөөдрийн хуралд идэвхтэй оролцсон та бүхэндээ баярлалаа ингээд 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хаасныг мэдэгдэж байна.

Б.Анхбаяр: Би асуулт асуух гэсэн юм. Өв залгамжлалаар санал өгөх нь хуулийн хүрээнд нээлттэй байдаг юм болов уу?

Б.Мөнхдалай: Хуулийн дагуу саналаа өгч байгаа. Энэ талаар тооллогын комисс хариу өгөх үү?

Нарийн бичгийн дарга И.Артём: За дэлгэцэн дээр итгэмжлэл болон өвлөх эрхийн гэрчилгээ харуулья.

Б.Анхбаяр: Ойлголоо өөр асуух зүйл байхгүй.

Б.Мөнхдалай: Өөр санал хүсэлт байхгүй бол хуралд идэвхтэй оролцсон та бүхэндээ баярлалаа, компанийн төлөө сэтгэл санаа зовж явж байгаад чинь баярлалаа, энэ удаагийн хурлыг хаасныг мэдэгдье.

Хурлаар хэлэлцэх асуудал 11:14 цагт дууссан тул хурал хаасныг мэдэгдэв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

И.АРТЁМ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:
ХУРЛЫН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ